



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас/факс: (976-11) 329084
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2016.06.14 № 3/2056
танай _____-ны № _____-т

Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Танай байгууллагын тус Хороонд хийсэн санхүүгийн аудитаар “2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан, үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу хянан үзээд материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн” гэсэн зөрчилгүй дүгнэлт гаргаж, зарим асуудлуудад зөвлөмж өгсөн билээ.

Хороо нь зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлуудын талаар дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн талаар

2000 оноос эхлэн 2014 оныг хүртэлх хугацааны үндсэн хөрөнгийн тайлангуудад бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэж, элэгдэл байгуулсан, элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож зардлыг нэмэгдүүлсэн байсныг 2015 оны санхүүгийн тайланд залруулага хийж санхүүгийн тайланг зөв болгосон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-оос үндсэн хөрөнгөд бүртгэсэн эдгээр бараа материалыг данснаас шилжүүлэн бүртгэх хүсэлтийг 2015 оны хагас жилийн тооллогын акт, Хорооны дэргэдэх Өмч хамгааллын байнгын зөвлөлийн шийдвэр, бусад холбогдох бичиг баримтуудын хамт хүргүүлсэн боловч Төрийн өмчийн хороо татан буугдах гэж байгаатай холбогдуулан аливаа өмч, хөрөнгийн асуудлаар шийдвэр гаргах боломжгүй гэсэн хариу өгсөн.

Түүнчлэн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дараа дээрх асуудлыг дахин тависан боловч Төрийн өмчийн хорооны асуудлыг Сангийн яам хариуцах болсонтой холбогдуулан Сангийн яамруу чиг үүрэг шилжсэний дараа шийдвэрлэнэ гэсний дагуу 2016 оны 4 дүгээр сард Сангийн яаманд дахин энэ асуудлыг тависан боловч улс даяар Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллого явагдах гэж байгаатай холбогдуулан эд хөрөнгийн хөдөлгөөн хийх, аливаа эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гаргаж болохгүй гэсэн тул үндсэн хөрөнгийн данснаас бараа материалыг одоогоор шилжүүлэн бүртгээгүй байна.

000380

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”, “Хэмнэлтийн горимд шилжих тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцүүлэн хэмнэлтийн горимд ажиллаж төсвийг хэмнэлттэй зарцуулж байна.

3. Санхүүгийн тайлагналын талаар

Азийн Хөгжлийн Банкны Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслөөс /цаашид ЯИЧСХНТ гэнэ/ үнэ төлбөргүйгээр Хороонд 2015 оны 3 дугаар сард шилжүүлсэн 9.7 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгасан боловч Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайланд тухайн дүн нь татагдахгүй байсныг “Интерактив Ай Би Ай” ХХК-наас програмист, нэвтрүүлэлтийн ажилтнуудыг дуудаж тухайн тайлант үед программыг засварлан тайланг зөв гаргасан. Энэ нь санхүүгийн программыг иж бүрэн нэвтрүүлэхэд шаардлагатай байсан ажлын нэг хэсэг юм.

4. ЯИЧСХНТ-ийн санхүүгийн тайлагналын талаар

Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй ЯИЧСХНТ нь 2012 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж ирсэн боловч Хорооны нэгдсэн тайланд нэгтгэгдэж байгаагүй. 2015 оны жилийн эцэст тухайн төслийн санхүүгийн тайланг нэгтгэж тайлагнах тухай Сангийн яамнаас шинэ журам батлагдсантай холбоотойгоор төслийн нягтлан бодогчийн ирүүлсэн санхүүгийн тайлангууд, дансны хуулбар, Сангийн яаманд өгсөн мэдээ зэргийг үндэслэн тайланг нэгтгэсэн. Төсөл нь 2016 оны 2 дугаар сард дуусгавар болж ажилтнууд нь ажлаасаа чөлөөлөгдсөн байгаа ч хагас жилээр дуусгалтын тайланг ирүүлэхээр болсон.


5. Дотоод хяналтын талаар

Хорооны Дотоод аудитын хэлтэс нь 3 хүнтэй бөгөөд хэлтсийн дарга, 2 референтийн хамт ажиллаж байна. Дотоод аудитын хэлтэс нь 2016 оноос эхлэн шалгалтын төлөвлөгөөг гарган, референт бүр ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгэн, Хорооны бүх нэгжүүдэд батлагдсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг хийн ажиллаж байна.

6. Төсвийн орлого болгох тухай акт

Хорооны Ажлын албаны даргын тушаалаар цалингүй чөлөө олгосон 1 ажилтан, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 1 ажилтанд байгууллагаас НДШ-д нийт 289.5 мянган төгрөг төлсөн төлбөрт 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 2/21 тоот акт гарган, төсвийн орлого болгохоор үүрэг өгсөний дагуу 289.5 мянган төгрөгийг тогтоосон хугацаанд буюу 2016 оны 5 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газрын төсвийн орлогын 900000601 тоот дансанд төвлөрүүлсэн. Төлбөрийн баримтын хуулбарыг хавсаргасан болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАЦАГДОРЖ